



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/114

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дахь заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Баатархайрхан багийн нутаг дэвсгэрт байрлах “Оож ван” ХХК /2836386/-ийн эзэмшлийн худалдаа, үйлчилгээний зориулалттай газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу 1 га /10000 метр квадрат/ газрыг “Ховд эвийн хүч” хоршоо /4073576/-нд 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг “Ховд эвийн хүч” хоршоонд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан хоршоотой газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-д даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/306 дугаар захирамжийн 1 дүгээр заалтыг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



№ 00521 D/Зак/А/14-Да